

Үзүүлэлтүүд:


<p><b>ДНБ 4.2%</b> 2017 оны I-р улирлын байдлаар</p>	<p>ГШХО 4-р сард <b>-30.8 сая ам.доллар</b></p>	<p>Төсвийн алдагдал <b>-412 тэрбум төгрөг</b></p>	<p>Инфляци <b>3.7%</b></p>	<p>Чанаргүй зээл <b>1158 тэрбум төгрөг</b></p>	<p>Валютын нөөц <b>1 тэрбум ам.доллар</b></p>
<p>Бүтээгдэхүүний цэвэр татвар 18 хувь, үйлчилгээний салбар 6 хувиар өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 4-р сарын байдлаар -30.8 сая ам.доллар өмнөх оны мөн үеэс 45 сая ам.доллараар буурав.</p>	<p>Төсвийн орлого 2666 тэрбум төгрөг, зарлага 3079 тэрбум төгрөг болж тэнцэл (412) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Өмнөх сараас 0.3 хувиар, оны эхнээс 4.4 хувь өсч өмнөх оны мөн үеэс 3.7 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 6.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 8.7 хувиар нэмэгдэж 1158 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 9.1% байна.</p>	<p>Монголбанкны валютын нөөц 4-р сард өмнөх оны мөн үеэс 20.3 хувь буюу 313 сая ам.доллараар буурч 1231 сая ам.доллар болов.</p>

<p><b>\$</b> Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш <b>2413.06 ₮</b></p>	<p><b>Орон сууцны үнийн индекс</b> <b>0.986</b> Өмнөх сараас 2.6%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 4.7%-иар буурав.</p>	<p><b>Монголбанкны бодлогын хүү</b> <b>12%</b></p>
--	--	--

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл өчигдөр хуралдаж, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээр эхний ээлжийн санхүүжилт болох 38.6 сая ам.доллар Монголбанкинд байршив.

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүллээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2015 он		2016 он		2017 оны 5-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	14.4	0.6	25.7	9.7	14.9	10.7
Төмрийн хүдэр	6.3	0.2	6.1	2.4	2.2	1.3
Зэсийн баяжмал	1.4	2.3	1.5	1.6	6.0	6.3
<b>Нийт</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>33</b>	<b>14</b>	<b>23</b>	<b>18</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5-р сарын 1-нээс эхлэн хадгаламжийн хүүгийн орлогод 10 хувийн татвар, авто машины насжилт, цилиндрин багтаамжаас хамааран 3-15 хувийн татвар, импортын тамхины гаалийн татварыг мөрдөж эхлэв.


**ДНБ**

ДНБ 2017 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 126.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 4.2 хувиар өсөв. ДНБ-ий 4.2 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар 18 хувь, үйлчилгээний салбар 6 хувиар өссөн нь нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 27.9 хувиар, зарлага 4 хувь өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 412 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 464.5 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 23.9 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.




**Валютын ханш**

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллантай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 401 төгрөг буюу 20.3 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 8 төгрөг буюу 0.4 хувиар буурч 2413.06 төгрөг болов.



**Инфляци**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 5-р сард өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсч, өмнөх оны эцсээс 3.7 хувиар өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өсөхөд тээврийн бүлэг 9.8 хувь, хүнсний бараа, ундаа, усны бүлэг, 2.1 хувь, хувцас, бөс бараа голлон нөлөөлсөн байна.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УЦХ, Монголбанк

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2017 оны 4-р сарын байдлаар 1231 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 10.9 хувь буюу 122 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 20.3 хувь буюу 313 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**


2017 оны 5-р сард 533.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 43.5 сая ш үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 382.2 (3.5 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. ТОП-20 дундаж индекс 2017 оны 5-р сард 12 788 нэгж болж, өмнөх сараас 211.4 нэгжээр буурч өмнөх оны мөн үеэс 1905.9 нэгжээр өсчээ.



\*Монголын хөрөнгийн бирж

**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 21 хувиар нэмэгдэж, өнгөрсөн сараас 4.2 хувиар өсч 12.9 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 11 хувиар, өмнөх сараас 4.9 хувиар өсч нийт мөнгөний 6.8 хувийг эзэлж байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2017 оны 5-р сард 9 их наяд төгрөг болж өмнөх сараас 244.1 тэрбум төгрөг буюу 2.8 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 16.9 хувиар буюу 1314.4 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 2 хувиар буюу 46.9 тэрбум төгрөгөөр буурсан бол төгрөгийн хадгаламж 4.4 хувиар буюу 290.9 тэрбум төгрөгөөр өсөв.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 5-р сард өмнөх сартай тэнцэж, өнгөрсөн оны мөн үеэс 11.2 хувиар нэмэгдэж 12.7 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1158 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 6.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 8.7 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.1% байна.




**Ипотекийн зээл**

2017 оны 5-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.8 хувь (30.9 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 11.9 хувь (439 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4 их наяд төгрөгт хүрэв. Тавдугаар сард нийт 512 зээлдэгчид 30.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 91362-д хүрэв. 2017 оны тавдугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.4 хувь нь төгрөгийн зээл, 0.6 хувь нь валютын зээл байна.



**Гадаад худалдаа**

2017 оны тавдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 4016 сая ам.доллар, үүнээс экспорт 2518 сая ам.доллар, импорт 1497 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 1020 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 2017 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсөхөд үнэт чулуу, металл гоёлын зүйлийн экспорт 63.2 сая ам.доллар буурсан хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 747.5 сая ам.доллар, үүнээс нүүрсний экспорт 789.3 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



\* Эх сурвалж УСХ, Монголбанк

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны 4-р сард -30.8 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 45 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт 1.8 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 38.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



\* Эх сурвалж Монголбанк

## Монгол Улсын гадаад өр

**Гадаад өр** 2017 оны нэгдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 5 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 24.9 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 19 хувь (950 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 3 хувь (693 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 23 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 30 хувийг бусад салбаруудын өр, 30 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.



\* Эх сурвалж Монголбанк

## Сарын онцлох үйл явдал

### 5.11

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-г 2012 оноос эхлэн 5 дахь жилдээ гарган, тайлангийн үр дүнг олон нийтэд танилцуулах хэвлэлийн хурал зохион байгууллаа. Сүүлийн 5 жил Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгуудын өрсөлдөх чадварын оноо харьцангуй өндөр байгаа бөгөөд өөрсдийн эрэмбээ хадгалсаар байна. Энэ жилийн тайланд ч мөн Орхон аймаг тэргүүлсээр байгаа бол удаах эрэмбэд Өмнөговь, Дархан-Уул аймгууд орлоо. Харин сүүлийн байруудад Архангай, Дундговь, Говь-Алтай аймгууд эрэмбэлэгдлээ. Өрсөлдөх чадвар сайтай аймгуудад ажиглагдаж байгаа нийтлэг шинж нь үйлдвэрлэл, дэд бүтэц хөгжсөн ажлын байр болон хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй сайн бүрдүүлсэн байв. Судалгааг хийж эхэлсэн 2012 онд Орхон аймаг 100 оноогоор тэргүүлж, Дундговь аймаг 27 оноотойгоор сүүлд эрэмбэлэгдэж байсан бол энэ жил Говь-Алтай аймаг 47 оноотойгоор сүүлд эрэмбэлэгдэв. Дэлгэрэнгүй судалгааны тайлантай [www.aimagindex.mn](http://www.aimagindex.mn) хаягаар орж танилцах боломжтой.

### 5.12-15

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2017 оны тавдугаар сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-ын дарга Ши Жинпиний урилгаар Бээжин хотноо зохион байгуулагдсан “Бүс ба зам” Олон Улсын хамтын ажиллагааны дээд түвшний чуулга уулзалтад оролцов. “Бүс ба зам” дээд түвшний чуулга уулзалтад дэлхийн 28 орны төр, засгийн тэргүүн нар болон НҮБ, Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагын удирдлага урилгаар оролцов. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат дээд түвшний дугуй ширээний уулзалтад оролцож, “Түншлэлийн төлөө бодлогоо уялдуулах нь”, “Хөгжлийн төлөө дэд бүтцийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” сэдвээр хуралдаанд үг хэлэв.